



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 314

Улаанбаатар хот

Г Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баян-Алдар” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 202,679 /хоёр зуун хоёр мянга зургаан зуун далан ес/ ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй “Монгорүматрикс гинко ББСБ” ХХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 19,720,000 /арван есөн сая долоон зуун хорин мянга/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нийт нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 19,922,679 /арван есөн сая есөн зуун хорин хоёр мянга зургаан зуун далан ес/ ширхэг хувьцаа болгон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦГХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Баян-Алдар” ХК /Б.Бадамцэцэг/-д үүрэг болгосугай:

1/ “Баян-Алдар” ХК-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхийг хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх;

2/ Компанийг өөрчлөн байгуулах, нэгдэж байгаа компанийн өмчлөлийн хөрөнгийг “Баян-Алдар” ХК-д шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, шинэчилсэн дүрмийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх;


3/ 2018 оны жилийн эцсийн тайланд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгах;

4/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-д заасан мэдээллийг тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

5/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 2 дугаар сарын 13-ний
өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Хувьцааны нэрлэсэн үнэ /₮/	Хувьцааны тоо ширхэг	Хувьцааны үнийн дүн /₮/
1	Ч.Чинзориг	100	10,000,012	10,000,012,000
2	Ш.Таро	100	9,719,988	9,719,988,000
	Нийт дүн		19,720,000	19,720,000,000